

## Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан

### зохион байгуулсан ажлын тайлан

2018.06.04

Амардалай

Дэлгэрцогт сум нь гэр бүлийн сарын ажлын хүрээнд 2018 оны 05 сарын 31-ний өдөр “Дархан бэр”, “Ачлалт ээж”, “Тэргүүний гэр бүл” шалгаруулан алдаршуулах ёслолын үйл ажиллагаа зохион байгууллаа.

3 ба түүнээс дээш тасралтгүй хүү төрүүлэн өсгөсөн ээжийг “Дархан бэр”-ээр, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн өндөр настан ээжийг “Ачлалт ээж”-ээр, сумын ард иргэддээ нэр хүнд сайтай, хөдөлмөрч, шударга, өв соёлоо дээдэлдэг, үр хүүхдээ зөв хүмүүжүүлсэн тэргүүний гэр бүлийг “Тэргүүний гэр бүл” шалгаруулах удирдамжийг багийн дарга нар, ард иргэдэд хүргүүлэн шалгаруулалтыг явууллаа.

“Ачлалт ээж” номинацид 1-р багийн малчин П.Чимэдцэрэн, 2-р багийн өндөр настан Ж.Умайжав, 2-р багийн малчин Ж.Лхагвасүрэн, 3-р багийн иргэн Ё.Пүрэвжав нар тус тус шалгарлаа.



“Дархан бэр” номинацид 1-р багийн малчин Маадорж, 1-р багийн иргэн Б.Хишигт, 2-р багийн малчин Ж.Дагиймаа, 2-р багийн иргэн Б.Сувдмаа, 2-р багийн малчин Ц.Мөнхцэцэг, 3-р багийн малчин Б.Чимэддорж нар тус тус шалгарлаа.



**“Тэргүүний гэр бүл”** номинацид 1-р багийн малчин Баасангийн гэр бүл, 1-р багийн малчин Ж.Баатарчулууны гэр бүл, 2-р багийн малчин С.Жаргалсайханы гэр бүл, 2-р багийн иргэн Ш.Даваагийн гэр бүл, 3-р багийн иргэн Б.Лхагвагийн гэр бүлүүд тус тус шалгарлаа.

